

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Прокурорын байгуулагад шаардлагатай эд хогшил  
худалдан авах

Төслийн дугаар: ОР-175/2019

Орхон аймаг  
2019 он

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2019 оны 09-р сарын 06-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Прокурорын байгуулагад шаардлагатай эд хогшил худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-175/2019**

**Орхон аймгийн ЗДТГ** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Прокурорын байгуулагад шаардлагатай эд хогшил худалдан авах** тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 08 цаг 00 минут**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 09 дүгээр сарын 13-ны 08 цаг 10 минутад** Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны **Сургалт мэдээллийн танхимд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын 70358570 утсаар авч болно.

**Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар  
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө  
Утас:70358570**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд заасан баримт бичгийг ирүүлнэ.   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 7.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>8. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 8.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>8.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <i>ТШӨХ-д</i> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>8.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.  |

**9. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

- 9.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1. Сүүлийн [1] жил буюу 2018 оны баталгаажсан санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>2. Борлуулалтын хэмжээ: <b>Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх</b></p> <p>3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <b>Санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх</b>  Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:  ✓ <i>Байгууллагын харилцах банкин дахь дансны үлдэгдэл /Банкны тодорхойлолт болон дансны хуулгаар тодорхойлно/</i>  ✓ <i>Харилцагч банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /шаардлага хангасан тохиолдолд зээл олгоно, судалж үзээд зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтуудыг үнэлгээнд харгалзахгүй./</i></p> <p>4. Сүүлийн [1] жил буюу 2018 оны туршлагын мэдээлэл ирүүлэх  Тавигдах шаардлага: Сүүлийн 1 жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төрлийн ажил хийж гүйцэтгэсэн байх</p> <p><i>Сүүлийн 1 жилийн ажлын гүйцэтгэлийн жагсаалт, үнийн дүн, гэрээ, хүлээлгэн өгсөн улсын комиссын акт, захиалагч болон ашиглагч байгууллагуудын тодорхойлолтуудыг эх хувиас скайнердаж ирүүлэх</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) –нд өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр илгээнэ.  Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:  Огноо: <b>2019 оны 09-р сарын 13-ны өдөр</b>  Цаг: <b>08 цаг 00 минут</b>  Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: ТЕНДЕРИЙГ ЦАХИМААР ДАРААХ ГАЗАРТ НЭЭНЭ.  Байшин, гудамжны нэр: <b>Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Нэг цэгийн үйлчилгээ, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны Сургалт мэдээллийн танхим</b>  Аймаг, хот: <b>Орхон аймаг, Баян-Өндөр сум</b>  Улс: <b>Монгол Улс</b>  Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:  Огноо: <b>2019 оны 09-р сарын 13-ны өдөр</b>  Цаг: <b>08 цаг 10 минут</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p>

	<ul style="list-style-type: none"> <li>➤ Үнийн санал маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>➤ Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>➤ Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх</li> <li>➤ Компанийн дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх</li> <li>➤ Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх</li> <li>➤ Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт ирүүлэх-Тодорхойлолт нь тендер зарлагдсан хугацаанаас хойш авсан байх шаардлагатай бөгөөд тухайн тендер нээсэн өдрийн байдлаар өр, төлбөргүй байна. Ирүүлсэн татварын тодорхойлолтын хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлэхийг анхаарна уу.Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. Тендер нээсэн өдрөөр татварын өртэй байвал шууд татгалзана.</li> <li>➤ Шүүхийн магадлагаа эх хувиас скайнердаж ирүүлэх</li> <li>➤ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>➤ Санхүүгийн тайлан-2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт эх хувиас скайнердаж ирүүлнэ.</li> <li>➤ Чадварын мэдээлэл: Өмнө нь гүйцэтгэсэн ажлын гэрээ, гэрээг дүгнэсэн актыг ирүүлнэ.</li> <li>➤ Нийлүүлэхээр санал болгож буй барааны техникийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх</li> <li>➤ Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх</li> <li>➤ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1 дэх заасан нөхцөл үүсээгүй тухай мэдэгдлийг ирүүлэх.</li> <li>➤ Тендерийн материалыг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх</li> <li>➤ Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаарх мэдэгдлийг ирүүлэх.</li> <li>➤ <u>Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй</u> эсэх талаар Харилцагч банкны тодорхойлолтыг харилцагч банк бүрээс авч эх хувиас скайнердаж ирүүлэх</li> <li>➤ Одоо хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг ирүүлнэ.</li> <li>➤ <u>Мөн тендерт оролцогч нь:</u> Захиалагч байгууллага Харьяа татварын байгууллага, Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, харилцагч банк болон бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг баталгаажуулан эх хувиар ирүүлэх /аль нэгийг орхигдуулсан тохиолдолд татгалзах үндэслэл болно./</li> <li>➤ Баталгаат хугацаа олгох баримт бичиг /1 жил/</li> </ul>
<p><b>ТОӨЗ 6.2</b></p>	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: БАГЦГҮЙ.</b></p>

**БАТЛАВ:**

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

**Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

- 1. Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо ширхэг хангасан байна.
- 2. Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолыг стандартын дагуу хийж эцсийн цэгт хүргэнэ. Түүнээс гарах бүх эрсдлийг нийлүүлэгч хариуцна.
- 3. Бараа хүргэх газар:** Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар
- 4. Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн дэлгэрэнгүй үзүүлэлт
1	Удирдлагын ажлын ширээ	ширхэг	1	1860*900*1675 мм, бор хүрэн өнгөтэй, ARTAZK Dozana –DZ898L эсвэл түүнтэй дүйцэх
2	Удирдлагын ажлын сандал	ширхэг	1	160 градус налдаг, хөл амраагчтай арьсан хүрэн өнгөтэй дугуйтай EUROBENCH DO9H-BLACK эсвэл түүнтэй дүйцэх
3	Удирдлагын туслах шүүгэ	ширхэг	1	1400*650*550 мм бор хүрэн өнгөтэй, REAIM Command R-ESR 14055 эсвэл түүнтэй дүйцэх
4	Удирдлагын туслах сандал	ширхэг	2	Савхин материалтай, албан тасалгааны зориулалттай сандал
5	6-8 хүний хурлын ширээ сандал	ширхэг	1	6-8 хүний хурлын ширээ, сандал 240*120*76 см, бор хүрэн өнгөтэй ARTAK-NA210-ROSEWOOD эсвэл түүнтэй дүйцэх
6	Сэтгүүлийн ширээ, сандал	ширхэг	1	Бор хүрэн өнгөтэй, 641 Coffee table transparent glass S-20 эсвэл түүнтэй дүйцэх
7	Буйдан	ширхэг	1	Албан тасалгааны ор болдог, Хэмжээ 1730*770*770 мм, арьсан хар өнгөтэй, Sofa 703 3 seat эсвэл түүнтэй дүйцэх
8	Ариун цэврийн өрөөний ком тавилга	ком	1	Тумбочка, босоо дүш ком, шкаф, иж бүрэн байх
9	Ханын стенка явган	ширхэг	1	161*46*71 ARTAK-611CB-MAHOGANY эсвэл түүнтэй дүйцэх
10	Төрийн сүлд, Аймгийн сүлд, Монгол орны газрын зураг том	ширхэг	1	Сүлд 50 см диаметрт, Газрын зураг урт 3 метр 50 см , өргөн 1 метр 5 см

	хэмжээгээр			
11	ДДЭШТ Антен	ширхэг	1	Иж бүрэн төхөөрөмжийн хамт
12	Телефон утас	ширхэг	1	Дугаар илрүүлэгчтэй Санах багтаамж: 100 нэр болон дугаар Сэрүүлэгчтэй Чанга яригчтай Тасралтгүй ярих цаг : 10 цаг Хүлээх горим: 6 өдөр Он, сар, цаг дэлгэцэн дээр гарна. Гар салдаг.
13	Усаа буцалгах, халаах зориулалттай цай чанах автомат аппарат ком	ширхэг	1	Төвийн шугамтай холбогддог Усаа буцалгах, халаах зориулалттай цай чанах автомат аппарат ком байна.

**5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Удирдлагын ажлын ширээ	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
2	Удирдлагын ажлын сандал	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
3	Удирдлагын туслах шүүгэ	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]



4	Удирдлагын туслах сандал	2	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
5	6-8 хүний хурлын ширээ сандал	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
6	Сэтгүүлийн ширээ, сандал	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
7	Буйдан	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
8	Ариун цэврийн өрөөний ком тавилга	1	ком	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
9	Ханын стенка явган	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
10	Төрийн сүлд, Аймгийн сүлд, Монгол орны газрын зураг том хэмжээгээр	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
11	ДДЭШТ Антен	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
12	Телефон утас	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

13	Усаа буцалгах, халаах зориулалттай цай чанах автомат аппарат ком	1	ширхэг	Орхон аймгийн Прокурорын газар	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
----	---	---	--------	---	-------------	----------	---

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах          | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- a. Барааг хүлээн авах комисс шалгаж , туршиж актаар хүлээн авна.
- b. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- a. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- a. Баталгаат засварын тусгай шаардлага. Шаардлагагүй.
4. Төлбөр (ГЕН – 7)
- a. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнэ төгрөгөөр төлөгдөнө.***
1. **Урьдчилгаа төлбөр: Олгохгүй.**
  2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Олгохгүй.**
  3. **Барааг хүлээн авч акт үйлдсэний дараа төлөх:**  
Захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлбөрийг 100 хувь олгоно.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
- a. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувиар хугацаа хэтэрсэн хоног тутамд тооцож гэрээний үнийг бууруулна.
- b. Алдангийн нийт дүн: Алдангийн дээд хязгаар нь гэрээний нийт дүнгийн 10 хувь байна. Дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцална.

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-аас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.